



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 4/94

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын газрын
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан дөрвөн аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан хоёр аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цахиур Төмөр ХХК-ийн "Роял" зочид буудлын 15/089, Корейна Тайм ХХК-ийн "Нийслэл" зочид буудлын 13/91, Спа Цогцолбор ХХК-ийн "Говь цогцолбор" зочид буудлын 14/77, Уранзандштайн ХХК-ийн "Хотару" дэн буудлын 13/23, Хөх Тэнгэрийн Заяа ХХК-ийн "Доллар" дэн буудлын 13/60, Цайны Зам Трейд ХХК-ийн "Атлантис" зочид буудлын 13/233 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

4. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Д. Батсүх* Д. БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 10 сарын 25 өдрийн
А/94 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.10.25

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Оноосон нэр | Байршил |
|-----|-----------------------------|----------------|---|
| 1 | Цахиур Төмөр ХХК | Роял | Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 32 |
| 2 | Корейна Тайм ХХК | Нийслэл | Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 100 |
| 3 | Спа Цогцолбор ХХК | Говь цогцолбор | Баянгол дүүрэг, 7-р хороо, Ард Аюушийн өргөн чөлөө |
| 4 | Цайны зам ХХК | Атлантис | Хан-Уул дүүрэг, 2-р хороо, То Вангийн гудамж 21/1 |

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2016 оны 10 сарын 25 өдрийн
А/94 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2016.10.25

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Оноосон нэр | Байршил |
|-----|-----------------------------|-------------|--|
| 1 | Уранзандштайн ХХК | Хотару | Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 32 |
| 2 | Хөх Тэнгэрийн Заяа ХХК | Доллар | Сонгинохайрхан дүүрэг, 19-р хороо, Үйлдвэрчний эвлэлийн 75 |

-ooOoo-